



АРДЧИЛСАН НАМЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛДӨХ ХОРООНЫ
ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот


Нэр дэвшүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 24, 25 дугаар зүйл, Үндсэн дүрмийн 6.4.1, 6.4.9.16, 6.4.10.1 дэх заалт, Ерөнхийлөгчид Ардчилсан намаас нэр дэвшигчийг тодруулах журмын 2.2 дахь заалт, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий газрын 2013 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 0033878 тоот албан бичиг, Цагдаагийн Ерөнхий газрын 2013 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 0002799 тоот албан бичиг, Үндэсний Зөвлөлдөх Хорооны 42 дугаар хурлын тооллогын комиссын 02 тоот тогтоол, Үндэсний Зөвлөлдөх Хорооны хуралдаанд оролцсон 181 гишүүний хүчинтэй 181 саналын 100 хувийн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны сонгуульд Цахиа овогтой Элбэгдоржийг Ардчилсан намаас нэр дэвшүүлсүгэй.
2. Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн үйл ажиллагаа, нэр дэвшигчийн хувиар цаашид хэрэгжүүлэхээр дэвшүүлж буй мөрийн хөтөлбөрийн үндсэн чиглэлийг сайшаасугай.

ДАРГА

ТЭРГҮҮЛЭГЧ



Н.АЛТАНХУЯГ

Ц.ОЮУНДАРЬ

Э.БАТ-ҮҮЛ

4/2
17

Цахиагийн ЭЛБЭГДОРЖ:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн

сонгуулийн мөрийн хөтөлбөр

2013-2017 он

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

Монгол Улсын төлөө зүтгэнэ гэдэг бол Монгол хүний төлөө зүтгэнэ гэсэн үг. Дээрх алтан зарчмыг хэлбэрэлтгүй мөрдөнө. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгосон Ерөнхийлөгчийн бүрэн эрх, үүргийг шударгаар хэрэгжүүлж ажиллана. Ард түмнийхээ нийтлэг эрх ашгийг ямагт дээдэлж, Монгол Улс, Монгол хүнд хэрэгтэй санал, санаачилгыг дэмжиж ажиллана.

Төр олон нийтийн ажил, улс төрийн амьдралд оролцож олсон өөрийн туршлага, мэдлэг, сургамжаа бүтээлчээр ашиглана. Улс орныхоо хөгжил дэвшил, ард түмнийхээ сайн сайхан амьдралын төлөө бүх боломжоо дайчлан ажиллана. Бүтээлч, үр ашигтай шинэчлэл өөрчлөлтийг түүчээлж дэмжинэ. Улс төржилт, талцлыг багасгаж, бүтээж, үйлдвэрлэж, хийхийг чухалчилна. Шударга ёсонд суурилсан эв нэгдлийг бэхжүүлнэ.

Ард иргэдийнхээ санаа бодлыг сонсож, улам ойр ажиллана. Тэдний хүсэн хүлээж байгаа шинэлэг ажлуудыг хийж хэрэгжүүлнэ. Олон нийтийн эрх ашигт нийцсэн, дэмжлэгийг нь хүлээсэн ажлуудаа үргэлжлүүлнэ. Улсын Их Хурал, Засгийн газар, орон нутгийн удирдлага, олон нийтийн төлөөлөл, иргэдтэйгээ идэвхтэй хамтран ажиллана. Төрийн тэргүүний үүрэгт ажлаа цаг алдалгүй үргэлжлүүлж “Хуулийн засаглалтай улс, Иргэний оролцоотой шийдэл, Бүтээгчдээ дэмжсэн бодлого, Байгальд ээлтэй хөгжил, Дэлхийд нэртэй Монгол” гэсэн үндсэн чиглэлийг баримтална.

Нэг. Хуулийн засаглалтай улс. Улс орноо албан тушаалтны засаглалаас хуулийн засаглалд шилжүүлнэ. Хуулийг албан тушаалтан захирдаг биш, албан тушаалтныг хууль захирдаг болгоно. Эрх зүй, аюулгүй байдал, төр болон улс төрийн салбарт тулгамдаж байгаа шинэтгэлийг үргэлжлүүлж хийнэ.

1.1 Хуулийг биелүүлэх нь хүн бүрийн нэр төрийн хэрэг. Хууль хэрэгжүүлэх, мөрдөх нь төрийн хүний үндсэн шинж. Ийм байдлаар Монголын уламжлалт хууль ёс, дэг жаягийг нийгэмд хэвшүүлэхэд онцгой анхаарна.

1.2 Монгол Улсад хуулийн засаглал, шударга ёсыг тогтоох ажлаа хөндлөнгийн нөлөөнд автахгүй, тууштай үргэлжлүүлнэ. Уг үйл явцыг эргэлт буцалтгүй болгож, үр дүнг нь үзнэ. Иргэдийнхээ дэмжлэгийг авч ажиллана.

1.3 Авлига, хээл хахууль, төрийн хүнд суртал, албан тушаалтнуудын хууль бус үйл ажиллагаатай үргэлжлүүлэн тэмцэнэ. Хууль зөрчигчидтэй хөрөнгө чинээ, нам улс төр, танил тал харгалзахгүй ижил тэгш хариуцлага тооцож ажилладаг жишгийг хуульчлан тогтоож хэрэгжүүлнэ.

1.4 Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг үргэлжлүүлэн боловсронгуй болгоно. Шалгах шаардлагатай өндөр албан тушаалтны бүрэн эрхийг түдгэлзүүлдэг болно. Авлигаас учирсан эдийн засгийн хохирлыг заавал талүүлнэ. Авлига өгснөө хуулийн дагуу илчилсэн иргэнд ял шийтгэл оногдуулахгүй байх бодлого баримтлана.

1.5 Шударга ёсны өгөөжийг ард түмэндээ алагчлалгүй хүртээнэ. Төрийн хууль, шийдвэр, бүх шатны байгууллага нь хүний эрх, эрх чөлөөг хангаж, ард иргэдийн нийтлэг сайн сайхны төлөө ажилладаг зөв соёлыг хэвшүүлнэ. Эвлэрүүлэн зуучлах, хохирлыг нөхөн төлөх үйлчилгээ болон хүний эрх, нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэх эрхийг баталгаажуулна.

1.6 Хууль шүүхийн шинэчлэлийг хийх, иргэдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн хуулиудыг үргэлжлүүлэн батлуулж хэрэгжүүлнэ. Цагдаа, онцгой байдал, дотоодын цэрэг, шийдвэр гүйцэтгэлийн болон хуулийн бусад байгууллагад ажиллагсдын хангамж, нийгэм эрх зүйн баталгааг дордуулахгүй, зөвхөн сайжруулах бодлого барина.

1.7 Төрийн албаны баталгааг сайжруулахад, төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэхэд анхаарна. Төрийн албанд ур чадвар, ёс зүй, мэргэжлийн шалгуурыг нэвтрүүлж, албан хаагчдын хууль бус халаа сэлгээг таслан зогсоох арга хэмжээ авна.

1.8 Төр нийгмийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээг бүрэн эрхийнхээ дагуу авч хэрэгжүүлнэ. Монгол Улсын аюулгүй байдлыг Монгол хүний аюулгүй байдалтай холбож авч үзнэ.

1.9 Аюулгүй байдалтай холбоотой хуулиудын төслийг цаг алдалгүй хэлэлцүүлж хэрэгжүүлнэ. Аюулгүй байдлыг хангах байгууллагын статусыг өргөх арга хэмжээ авна.

1.10 Батлан хамгаалах болон хил хамгаалах байгууллагын бие даасан байдлыг баталгаажуулж, үүрэг гүйцэтгэх чадавхыг нь нэмэгдүүлнэ. Энхийг сахиулах үйл

19

ажиллагааг бэхжүүлэх болон цэрэг, эх оронч хүмүүжлийг иргэдэд олгоход анхаарна.

1.11 Цэргийн алба хаасан болон онцгой үүрэг биелүүлсэн иргэдийн үнэлэмжийг дээшлүүлж, сургуульд суралцах, төрийн болон хариуцлагатай албанд ажиллах шалгуурт оруулж тооцдог болгоно. Оюутан-цэрэг хөтөлбөрийг судалж хэрэгжүүлнэ.

1.12 Хуулийн засаглал, хүн амын амьжиргааны түвшин, нээлттэй байдал, өрсөлдөх чадвараараа олон улс болон бүс нутгийн түвшинд чансаагаа үнэлүүлж Монгол Улсын нэр хүндийг өсгөхийн төлөө ажиллана.

Хоёр. **Иргэний оролцоотой шийдэл.** Монгол хүний төлөө хийж байгаа ажил, санал санаачилга бүрийг дэмжинэ. Хүний эрхийг хүнд нь, иргэний эрхийг иргэнд нь бодитой шилжүүлнэ. Улс орондоо иргэний, хүмүүнлэг, ардчилсан нийгэм байгуулах ард түмнийхээ сонголтыг улам баталгаажуулна. Энэ их үйлсийг манлайлж ажиллана.

2.1 Иргэдийн оролцоог хуульчлан баталгаажуулна. Иргэдээсээ асууж шийддэг шууд ардчиллын тогтолцоог тууштай нэвтрүүлнэ. Иргэний санаачилгыг дэмжиж урамшуулна.

2.2 Орон нутаг, нутаг дэвсгэрийн анхан шатны нэгжид эдийн засаг, санхүү, боловсон хүчний эрх мэдлийг шилжүүлнэ. Татвар хураамжийн хувь тогтоох, чөлөөлөх, орлогоо захиран зарцуулах эрхийг орон нутагт өгнө. Мөн боловсон хүчнийхээ сонголт шалгаруулалтыг бие дааж хийх, томилох, чөлөөлөх эрхийг орон нутагт олгоно.

2.3 Газар, өмч хөрөнгөө эзэмших, өмчлөх, ажил, аж ахуй эрхэлж амьдралаа өөд нь татах иргэний эрхийг хуулиар баталгаажуулна. Захиргааны болон албан тушаалтны дур зоргоор хүний эрх, өмч хөрөнгө, бизнес, хууль ёсны үйл ажиллагаанд саад болдог, халддаг явдлыг таслан зогсооно. Хүний хохирсон эрхийг сэргээдэг, хохироосон төрийн байгууллага, албан тушаалтан хариуцлага хүлээдэг болгоно.

2.4 Ашигт малтмалын салбар дахь хууль бус, оршин суугчдынх нь эрх ашгийг зөрчсөн, замбараагүй үйл ажиллагааг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаач, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор үргэлжлүүлэн цэгцэлнэ. Эрдэс баялгийн салбарын бодлогыг аль болох иж бүрэн, бүтэн болгоно. Энэ салбарт баримтлах төрийн бодлогыг гаргаж, эрх зүйн орчныг нь боловсронгуй болгож, иргэдийн хяналт оролцоог нэмэгдүүлнэ.

2.5 Тухайн нутаг дэвсгэрт байгаа баялгийг хайх, олборлох, ашиглах асуудлыг шийдвэрлэх анхдагч эрх нь тэнд амьдарч байгаа иргэд, орон нутгийн удирдлагад байхаар хуульчилж хэрэгжүүлнэ. Эзэн нь эрхээ, баялгаа мэдэх зарчмыг төрийн бүх шатанд мөрдлөг болгоно.

2.6 Төрөөс иргэд, мэргэжлийн, аж ахуйн, олон нийтийн байгууллагад шилжүүлэх ажил үйлчилгээг хуулиар тогтоож, төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг тууштай сааруулах, зардал бууруулах чиглэлд санаачилга гаргаж ажиллана. Хууль, стандартыг чанд мөрдөж, чанаржуулж урагшлахыг зөв гэж үзнэ.

2.7 Улс төрийн намыг тойрсон эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгож намын гишүүнчлэл, өмчлөл, санхүүжилт, зохион байгуулалтын асуудлыг орчин үеийн жишигт нийцүүлэн шийдвэрлэнэ.

2.8 Нийслэлд төвлөрлийг сааруулах, дагуул хотууд байгуулахыг дэмжинэ. Дархан, Эрдэнэт болон аймгийн төвүүд, мөн хүн амын төвлөрөл ихтэй газруудад хотын статус олгох асуудлыг судалж шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.9 Хөрөнгө оруулалтын бодлогыг тухайн нэгжид оршин сууж байгаа хүн амын тоотой уялдуулж шийдвэрлэхийг дэмжинэ. Энэ нь хүн нэг бүрт ноогдох хөрөнгө оруулалтын хэмжээ ижил байна гэсэн үг. Орон нутагт шинэ баг, шинэ сум, хот сууринд шинэ хороо, шинэ дүүрэг төслүүдийг ажил болгоход санаачилга гаргаж оролцоно.

2.10 Хот суурин газруудын агаарын болон хөрсний бохирдол нийтийн үйлчилгээнд тулгамдаж байгаа асуудлыг тухайн шатны Засаг дарга, удирдлагын санаачилгад үндэслэж ажил хэрэг болгоход дэмжлэг үзүүлнэ. "Утааны аюулыг зун ч битгий март" гэсэн зарчим баримталж ажиллана.

2.11 Төрийн байгууллага, албан тушаалтны төсвийн зарцуулалтыг олон нийтэд ил тод, нээлттэй, хяналттай болгоно. 2013 оны 9 дүгээр сарын 1-нээс төрийн бүх байгууллага, төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжүүдийг шилэн данстай болох ажлыг эхлүүлнэ. Энэ талаар зарлиг гаргаж улмаар хууль санаачилж мөрдүүлнэ.

2.12 Төрөх болон хүүхдийн эмнэлэг, цэцэрлэг, сургууль, спорт, соёлын байгууламжийг барих хөрөнгө оруулалтыг байнга нэмэгдүүлж байх шаардлагыг УИХ, Засгийн газар, орон нутагт тавьж, хэрэгжилтийг нь ард иргэдтэйгээ хамтарч хянана.

2.13 Ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрөх насны эхчүүд, залуу гэр бүл, оюутнуудын болон цэргийнхэн, цэрэгжсэн байгууллагынхны өмнө

тунгамдаж байгаа асуудлыг тэдний төлөөлөлтэй хамтарч шийдүүлэхэд анхаарна. Амьдрал дээр олон тоотой ч шийдвэр гаргах танхимд цөөнх болсон нийгмийн бүлгийн асуудлыг Ерөнхийлөгчийн хувьд биөчлэн төлөөлж ажиллах болно.

2.14 Багш, эмч, сувилагч, асрагчийг хөгжүүлэх, мэргэжил дээшлүүлэхэд онцгой анхаарна. Гадаад улс оронд ижил төстэй байгууллага сургууль, эмнэлгийн үйл ажиллагаатай танилцах, богино хугацаагаар суралцах, дадлагажих олон улсын солилцоо хөтөлбөрийг дэмжинэ. Тухайн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн, байгууллагатай тулж ажиллана.

2.15 Дунд сургуулиудад хэрэгжих "авьяас", "ухаалаг сургууль" хөтөлбөрүүдийг дэмжинэ. Хөдөө хот, баг сум ялгаагүй, хотын төв гэр хороололд адилхан хурд багтаамжтай интернет, харилцаа холбооны үйлчилгээг нэвтрүүлэх санаачилгыг дэмжиж ажил болгоно. Энэ салбарт иргэдийн мэдээлэл, үйлчилгээ авах эрхийн ялгааг бүрэн арилгана.

2.16 Оюутан залуус, иргэдээ олон улсын нэр хүндтэй сургуульд элсэн суралцах, улс орондоо хэрэгцээтэй мэргэжил эзэмших боломж нөхцөл бүрдүүлэхэд тусална. Хэлний бэлтгэл сургалтад анхаарна. Нэн чухал болон инженерийн боловсролтой иргэдээ бүртгэж дэмжинэ.

2.17 Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгоход анхаарна. Өвчтөний түүх, бүртгэлийг цахимжуулж, иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхийг чөлөөтэй болгоно. Өндөр өртөг бүхий оношилгоо, эмчилгээ, хөнгөвчлөх болон өрхийн эмнэлгийн шаардлагатай үйлчилгээг даатгалд хамруулах бодлогыг дэмжинэ.

2.18 Сургуулийн өмнөх насны хүүхэд асрах үйлчилгээ, бичил цэцэрлэг, түүний стандарт шаардлагыг хуульчилж дэмжинэ. 0-2 хүртэл насны хүүхдийг гэрээр харах, 2-5 хүртэл насны хүүхдийг цэцэрлэгт хамрагдах бодлого, санаачилгыг дэмжинэ. Таваас дээш тооны хүүхэд харж байгаа хүний ажлыг баталгаажуулж, гэрчилгээ олгоно. Энэ ажлыг УИХ-ын эмэгтэй гишүүдийн санаачилгад түшиглэж хэрэгжүүлнэ.

2.19 Бага сургуулийг аав ээж, хүүхдийн амьдардаг орчинд ойртуулж барих, оюутны дотуур байр, эмнэлгийн үйлчилгээг шийдвэрлэх, залуу гэр бүл, ахмад настан, ажилчдад зориулсан орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэх санаачилгыг дэмжинэ.

2.20 Залуу гэр бүлийг орон сууцны зээлд хамрагдах боломжийг нэн тэргүүнд, цаашид ажилтай, орлоготой иргэн бүр орон сууцны зээлд хамрагдаж болох нөхцөлийг бүрдүүлнэ. Анхны жилээ ажиллаж байгаа, хуримтлал бий болгож

4
22

амжаагүй залууст болон ахмад настнуудыг нийтийн орон сууцаар хангах санаачилгыг дэмжинэ.

2.21 Иргэд, залуусын сайн санааны болон бусдад туслах санаачилгыг дэмжиж ажиллана. Энэ зорилгоор “Ардын элч” хөтөлбөр санаачилж оюутан, залуус, ажил хэрэгч иргэдийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.

2.22 Төр, бизнес, олон нийтийн байгууллагын бүх шатанд эмэгтэйчүүдийн оролцоог урьдын адил дэмжинэ. Архигүй, тамхигүй, хоггүй эрүүл ажиллаж амьдрах хөдөлгөөнийг дэмжиж ард иргэдийн зөв, амгалан тайван, аз жаргалтай амьдрах хэв шинжийг бүрдүүлэхэд анхаарна.

2.23 Үндэснийхээ ёс заншил, соёл уламжлал, бахархал түүхийг сэргээж, иргэд хойч үедээ өвлүүлж үлдээхэд чиглэсэн бодлогоо эрчимжүүлнэ. Эх орон, улс үндсээ хайрлах, бахархах, хөгжүүлэх эрмэлзлийг дэмжинэ. Иргэний боловсрол, эрх чөлөө, ардчиллын хөгжил дэвшилд хийх хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

Гурав. Бүтээгчдээ дэмжсэн бодлого. Бүтээлч, үйлдвэрлэгч, ажил хэрэгч иргэдээ дэмжиж ажиллана. Иргэдээ ажилтай, амьдралдаа хүрэлцэх орлоготой байх боломжийг бүрдүүлэхэд анхаарна. Худалдааны эдийн засгаас үйлдвэрлэлийн эдийн засаг руу шилжих бодлого, үйл ажиллагааг дэмжинэ.

3.1 Жижиг, дунд бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдэд учирч байгаа төрийн болон татвар, зээлийн хүндрэл, захиргааны шинжтэй, хууль бус дарамтыг хөнгөвчлөх, шийдвэрлэхэд чиглэсэн санаачилгыг дэмжинэ.

3.2 Төсвийн хөрөнгөөр гадны бараа бүтээгдэхүүн худалдаж авахыг эрс хязгаарлах, улмаар хориглох бодлого баримтална. Төсвийн санхүүжилт, худалдан авалтаар зөвхөн дотоодын үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, ажлын байр, үйлчилгээг дэмжихийг зөв гэж үзнэ. Мөн хөрөнгө оруулагчид, аж ахуйн нэгжүүдэд энэ шаардлагыг тавина.

3.3 Иргэдийн оролцоотой баялаг бүтээх санаачилгыг бодит ажил болгоно. Аж ахуйн нэгжүүдийн олон нийтийн хэлбэрт шилжих, ил тод, хариуцлагатай байх үйл явцыг дэмжинэ. Баялаг бүтээхэд хувийн хэвшлийн оролцоо, иргэдийн хяналтыг нэмэгдүүлнэ.

3.4 Хөрөнгийн зах зээлийн хөгжил, тогтолцоог олон улсын жишигт хүргэнэ. Иргэдийнхээ нэрийн данс, ирээдүйд зориулсан хадгаламжийг уул уурхайн салбараас олж буй орлогод түшиглэж баталгаажуулахад анхаарна. Ирээдүй үедээ өр биш хуримтлал үлдээх бодлого баримтална.

Хөрөнгө оруулалтын орчныг тодорхой, тогтвортой болгож, хөрөнгө оруулалтыг хамгаалах, өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэхэд анхаарна.

Эрүүл мэнд, боловсрол болон дэд бүтэц, үйлдвэрлэл, өндөр технологид хөгжиж байгаа хөрөнгө оруулалтыг урамшуулна. Мөн орон нутаг, алслагдсан бүсүүдийг хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

Дэд бүтэц, үйлдвэржилт, эрчим хүч, уул уурхай, хотжилт тойрсон тулгамдсан байдлыг шат дараатай, бүсчилж шийдвэрлэх бодлогыг УИХ, Засгийн газартай хамтран хэрэгжүүлнэ. Эдгээр асуудалд олон нийтийн анхаарлыг чиглүүлж, төр засгийн байгууллага, албаны хүмүүсийг шахаж шаардаж ажиллана.

Төмөр зам шинээр барих, засварлаж өргөтгөх, дотоодын нөөц баялагтаа ашиглан туургаж шатах тослох материал, цахилгаан үйлдвэрлэх, үнэ тарифын ялгааг хамгаасгах боломжийг цаг алдалгүй хэрэгжүүлэхэд шаардагдах дэмжлэгийг үзүүлнэ.

Газар доорх баялгийг газар дээрх баялаг болгох бодлого, үйл ажиллагааг зөв зохиож үзнэ. Ашигт малтмалын орлогыг иргэдийнхээ хэрэгцээ, нийтлэг эрх ашиг, улс орныхоо хөгжил дэвшлийг хангах хөрөнгө оруулалтад чиглүүлнэ.

Уул уурхай, мал аж ахуй, байгалийн гаралтай бүтээгдэхүүнийг түүхийгээр нь экспортлохыг хязгаарлана. Аливаа түүхий эдийг үндэсний үйлдвэрлэгчид хийж үйлдүүлэхийг урамшуулна. Нэмүү өртөг шингээж, боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн хийж худалдаалахыг дэмжинэ. Үндэсний экспортыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

Үндэсний баялаг бүтээх, хүнсний бие даасан аюулгүй байдлыг хангахад шаардлагатай үүрэг гүйцэтгэдэг малчид, тариаланчид, ногоочид, үйлдвэрлэгчдийг тусгай бодлогоор дэмжинэ. Эрх ашиг, зах зээлийг нь хамгаална. Гадаад, дотоод харилцааг нь өргөжүүлнэ. Энэ салбарын дэмжлэг, урамшууллын өнөөгийн хүрсэн түвшинг баталгаажуулах, нэмэгдүүлэх, улам боловсронгуй болгоход анхаарна.

Монгол Улсын эдийн засгийн бие даасан байдлыг баталгаажуулахад онцгой анхаарна. Улсынхаа байршлын давуу тал, нөөц боломжийг ашиглаж дэд бүтэц, эрчим хүч, үйлдвэрлэл, аялал жуулчлал, өндөр технологи, бараа үйлчилгээ, санхүүгийн бизнесийг хөгжүүлэх чиглэл баримтална.

Иргэдээ гадагш явуулдаг биш, иргэдээ гаднаас ирэхэд нь, ажил үйлдвэрлэл хэрхлэхэд нь тусалдаг бүтцийг бий болгоно. Мэргэжилтэй ажилчин бэлтгэх, ажлын байраар хангахад чиглэсэн бодлогыг тэргүүн зэрэгт тавина. Насанд хүрэгчдийг мэргэшүүлэх Үндэсний хөтөлбөрийг дэмжиж хэрэгжүүлнэ.

3.14 Гадаад ажиллах хүчин тойрсон шалгуур, мэргэжил, хяналт зохицуулалттай холбогдсон асуудлыг шинээр авч үзнэ. Хууль зөрчсөн, хугацаа хэтэрсэн этгээдүүдийг албадан гаргах, хууль зөрчигчидтэй тооцох хариуцлагыг чангатгах арга хэмжээ авна.

3.15 Ажилчин хүний хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, эрүүл, аюулгүй ажлын орчныг бүрдүүлэх, бүтээмжийг дэмжих хөдөлгөөнийг Үйлдвэрчний байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ. Аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад хариуцлагатай, ёс зүйтэй, дарамт ялгаваргүй, ил тод, олон нийтийн хяналт бүхий ажиллах орчин бүрдүүлэхэд анхаарна.

Дөрөв. Байгальд ээлтэй хөгжил. Иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах эрхийг хангасан, байгальд ээлтэй, ногоон хөгжлийн бодлогыг Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх зорилт гэж үзнэ.

4.1 Байгаль орчны асуудалд үргэлжлүүлэн онцгой анхаарна. Хүн, байгаль гэсэн бодлогын тулгуур баганаа байнга бэхжүүлж ажиллана. Төрийн бух шатанд аливаа асуудлыг иргэнтэйгээ, байгаль орчинтойгоо уялдуулж шийддэг хэвшлийг тогтооно.

4.2 Байгаль орчныг сэргээх, мод тарих, усны нөөцийг нэмэгдүүлэх, цөлжилт хуурайшилттай тэмцэх чиглэлд ажиллаж байгаа иргэд, олон нийт, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг тодорхой бодлогоор дэмжинэ.

4.3 Байгаль орчны салбарт ажиллагсдын хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлнэ. Байгаль орчны хамгааллыг мэргэжлийн байгууллагууд, иргэдийн болон орон нутгийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлэхэд анхаарна.

4.4 Хүрээлэн байгаа орчиндоо ээлтэй хөгжил, санаачилга, технологийн шийдлийг дэмжинэ. Дэд бүтэц, үйлдвэрлэл, эрчим хүчний хөгжлийг хүрээлэн байгаа орчинд нь уялдуулж шийдвэрлэх бодлого баримтална.

4.5 Байгаль орчны эсрэг зөрчил, гэмт хэргийн зүйлчлэлийг олон улсын жишигт нийцүүлэн төрөлжүүлж, хохирлыг төлүүлэх, нөхөн сэргээх, хариуцлага хүлээлгэх механизмыг тодорхой болгоно.

4.6 Байгаль орчинтой холбоотой хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж, хэрэгжилт, шалгуурыг нь орчин үеийн шаардлагад нийцүүлнэ. Байгаль орчны төрийн бус байгууллагуудын иргэний зөвлөлтэй нягт хамтран ажиллана.

4.7 Монгол Улс уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, усны асуудал болон байгаль орчныг нөхөн сэргээхэд чиглэсэн олон улсын санаачилгад идэвхтэй оролцоно. Мөн тухайн асуудлаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт хамрагдаж, тэдгээрийн үр шимийг хүртэгч байхыг эрмэлзэнэ.

4.8 Усны асуудлаар НҮБ-ын конвенц санаачилж батлуулах, НҮБ-ын төрөлжсөн байгууллага байгуулах санаачилгаа үргэлжлүүлж ажил хэрэг болгоно.

4.9 Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн судалгааг эрчимжүүлж, олон улс, бүс нутгийн санаачилгад идэвхтэй хамтарч оролцоно. Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний Азийн түшиц орон, түүнд түшиглэсэн үйлдвэрлэл, сүлжээ байгуулах зорилготой хөтөлбөр, судалгаа төслийг үргэлжлүүлнэ.

4.10 Цацраг идэвхт бодис, цөмийн эрчим хүч ашиглахтай холбоотой асуудлаарх төрийн бодлогыг шинэчилж тогтооход олон нийтийн үүсгэл санаачилгын болон мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтарч ажиллана. Байгаль орчин, иргэдэд аюултай бол энэ төрлийн бизнес, үйл ажиллагаанаас татгалзах бодлого баримтална.

4.11 Цөмийн хог хаягдлыг Монгол Улсад булшлахгүй, байрлуулахгүй байх санаачилгаа тууштай баримтална. Энэ чиглэлд иргэд, олон улс, мэргэжлийн байгууллагын дэмжлэгийг авч, Ерөнхийлөгчийн хувиар манлайлал үзүүлж ажиллана.

4.12 Монгол орны онгон дагшин байгаль, давтагдашгүй ховор, мөн эмзэг экосистемийг хамгаалахад чиглэсэн санаачилгад тулгуурлан “Байгалийн нөөцийн Үндэсний парк” байгуулах зарлигийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

4.13 Байгаль, уул усаа шүтэж, хамгаалж ирсэн ахмад үе, ард иргэдийнхээ ёс заншлыг хүндэтгэн сахиж, өвлүүлэхэд анхаарч ажиллана. Тахилгат уул овоо, усны эхийг хамгаалах, цэвэрлэх зан үйл, санаачилгыг дэмжинэ.

4.14 Иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчныг хамгаалах, хүрээлэн буй орчныхоо талаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцоход чиглэсэн олон улсын гэрээ хэлэлцээрт Монгол Улс нэгдэх, үндэсний хууль тогтоомжоо тэдгээрт нийцүүлэх үйл явцыг дэмжинэ.

Тав. Дэлхийд нэртэй Монгол. Улс орныхоо нэрийг олон улсад сайнаар гаргахад онцгой анхаарна. Монгол Улсын аюулгүй, тусгаар, бие даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа, санал санаачилгыг бүх талаар дэмжиж ажиллана.

5.1 Олон талын болон хоёр талын харилцаанд үндэсний эрх ашгаа дээдлэх, хуулийг сахих, харилцан ашигтай, найрсаг хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлогыг чанд баримтална.

5.2 Монгол Улсын олон тулгуурт, нээлттэй гадаад бодлогыг уламжлан хэрэгжүүлж, хөрш орнууд болон бусад улс, олон улсын байгууллагатай идэвхтэй хамтран ажиллана.

5.3 Бүс нутгийн эдийн засаг, дэд бүтэц, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрт Монгол Улсын оролцоог хангахад анхаарч ажиллана.

5.4 Нэгдсэн Үндэстний Байгууллага, Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүд, Ерөнхий Ассамблейн хүрээнд тогтоосон харилцаа холбоо, манай орны аюулгүй байдал, санал санаачилгыг баталгаажуулсан шийдвэрийн үр өгөөжийг нэмэгдүүлж, хэрэгжилтийг хангана.

5.5 Ази, Номхон далай, Европын Холбоо, олон улсын төрөлжсөн байгууллагуудтай тогтоосон харилцаа, яриа хэлэлцээг улам баталгаажуулж, тодорхой ажил хэрэг болгоно.

5.6 Ази тивийн хэмжээнд хүний эрх, хуулийн засаглал, нээлттэй байдлыг бэхжүүлэх зорилготой Азийн түншлэл, зөвлөл, ардчиллын сүлжээ, мөн Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх Улаанбаатарын яриа хэлэлцээ, санаачилгуудаа бодит ажил болгоно.

5.7 Ардчиллын боловсролыг дэмжих, иргэний нийгмийг бэхжүүлэх, авлигыг үл тэвчих, туршлага сургамжаа бусадтай хуваалцах, сонгууль ажиглах, хамтарсан сургалт явуулах талаар бусад орон, олон улсын байгууллагатай идэвхтэй ажиллана. Энэ чиглэлээр "Олон улсын хамтын ажиллагааны сан" ажиллуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлэхэд анхаарна.

5.8 "Архигүй, эрүүл Монголын төлөө" уриаг улс орондоо хэрэгжүүлж байгаа ололт амжилтаа тулгуурлаж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгээр "Архины хор хөнөөлийн тухай" олон улсын конвенц батлуулах чиглэл баримтална.

5.9 Монголын түүх, бахархалтай холбоотой түүхэн баримтуудыг судлах, эмхэтгэл гаргаж сурталчлах, боломжтойг нь эх орондоо авч ирэх талаар санал, санаачилга гаргана.

5.10 Олон улсад Монгол судлалыг бэхжүүлэх, дэлгэрүүлэх ажлыг улам эрчимжүүлнэ. Монгол судлаачдын гавьяа зүтгэлийг үнэлэх, бүтээл туурвилыг нь олны хүртээл болгох, туршлага, мэдлэгээ солилцоход нь дэмжлэг үзүүлнэ. Ийм зорилгоор бие даасан сан, судалгааны төв, сургууль байгуулж ажиллахыг дэмжинэ.

5.11 Гадаад улс орнуудад ажиллаж, суралцаж, амьдарч байгаа иргэдтэйгээ холбоотой байж, тэдэнд тулгамддаг асуудлыг шийдвэрлэхэд анхаарч ажиллана. Мөн иргэдээ эх орондоо ирж ажиллаж амьдрахад нь туслах хөтөлбөр, бодлогыг хэрэгжүүлнэ.

5.12 Монгол үндэстний соёл, урлаг, спорт, хүмүүнлэгийн харилцааг идэвхжүүлэхэд анхаарна. Мөн Монгол хүмүүсийг уугуул нутагтаа ирж амьдрах, ажиллах, суурьшихад нь бусад орны жишгээр дэмжлэг, туслалцаа үзүүлнэ. Энэ чиглэлд эрх зүй, бодлогын шинэтгэл хийнэ.

5.13 Улс орныхоо нэрийг олон улс, дэлхийд сайнаар гаргаж байгаа иргэдээ дэмжиж урамшуулна. Монгол үндэстний уламжлалт соёл, зан үйлийг олон улсад сурталчлах бүхий л боломжийг ашиглана.

5.14 Монгол Улс нь НҮБ-ын гишүүн бүх оронтой дипломат харилцаа тогтоохыг чухалчилна. Улс орныхоо бие даасан, аюулгүй байдлыг улам баталгаажуулах, гадаад харилцаа холбоог өргөжүүлэх, Монгол Улсын олон улс, дэлхийгээс хамаарах хамаарлыг нэмэгдүүлэн бэхжүүлэхэд онцгой анхаарна.

Би эх орондоо, ард иргэддээ хэрэгтэй цагт нь тусалдаг Ерөнхийлөгч байх болно. Монгол хүний төлөө зүтгэлээ Монгол Улсын төлөө зүтгэл гэж үзнэ. Мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхийн төлөө өөрийн бүх мэдлэг, чадвар, туршлага, боломжоо дайчилж, бусдын тус дэмийг авч ажиллана.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль нь нийт монголчуудын ялалт, амжилт, хөгжил дэвшлийн төлөөх эрхэмсэг өрсөлдөөн гэдэгт би итгэдэг. Бусдыг муулахгүй, өөрийгөө өмөөрөхгүй өрсөлдөнө. Хийх ажил, хөтөлбөрөө тайлбарлаж иргэдийнхээ дэмжлэгийг авахыг хичээж зүтгэнэ. Сонгуулийн явцад гарч байгаа санаа бодол, хөтөлбөр, санаачилгыг бодлого, үйл ажиллагаандаа тусгаж ажиллана. Нийт иргэдээ жигд төлөөлж, эв нэгдэл, шударга ёсыг эрхэмлэнэ.

Би улс орноо, ард түмнээ зөв замд хөтөлсөн Ерөнхийлөгч байна. Ард түмний минь буян заяа, ажил үйлс, золбоо хийморь нь байнга өөдөө байг. Бүгдээрээ хамтдаа Монгол Улсын төлөө зүтгэцгээе.

Эх орон, эрх чөлөө хоёр минь бүтэн байг.

Миний Монгол Мөнх Оршиг.

Улаанбаатар хот

2013.05.11